

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	
1. Төслийн нэр, хүчин чадал:	“Газрын тос боловсруулах үйлдвэр” барих төсөл Хүчин чадал: 1.5 сая тонн түүхий тос боловсруулах
2. Төсөл хэрэгжих салбар, дэд салбар:	Хүнд үйлдвэр, нефть – химийн үйлдвэрлэлийн салбар
3. Төслийн хэрэгжих хугацаа: Эхлэх Дуусах	2017. I-II улирал 2020. IV улирал
4. Төслийн төсөвт өртөг/тэрбум ам.долл/:	0.9 - 1
5. Хэрэгжүүлэгч яам, байгууллага:	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Оролцогч талууд: Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид
ТӨСЛИЙН ТАЛААРХ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ	
6. Байршил:	Говийн бүс. Дорноговь аймаг  2 үндсэн байгууламжаас бүрдэнэ. Үүнд:  <i>1.Газрын тос боловсруулах үйлдвэр</i> <i>2.Түүхий тос дамжуулах хоолой</i>
7. Бүтээгдэхүүн:	- Автобензин 95/98, дизель түлш, ахуйн болон авто тээврийн шингэрүүлсэн хий, битум, мазут бусад дагалдах химийн нэгдлүүд
8. Төслийн үндэслэл:	- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 2014 оны 14/06 - Засгийн газрын 2015 оны 113 дугаар тогтоол - Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
9. Төслийн зорилго:	- Дотоодын олборлож буй түүхий газрын тосыг түшиглэн үндэсний үйлдвэр байгуулна. - Газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлаас гаргана. - Шатахууны хангамжийн найдвартай байдлыг бий болгоно. - Гадаад руу гаргах валютын урсгалыг бууруулна. - Нефть-химийн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлнэ.
10. Төслийн техникийн баримт бичиг боловсруулсан байдал	- Засгийн газрын захиалгаар Унгар улсын Евройл компани Үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, 2016 оны 3 дугаар сард бэлэн болгосон. - 2016 оны 4 дүгээр улиралд төслийн санхүүжилт, төслийн нэгжийн асуудлыг шийдвэрлэнэ. - 2017оны I улиралд нарийвчилсан ТЭЗҮ болон FEED-ийг боловсруулж дуусгана. - 2017 оны II улиралд барилгын ажил эхэлнэ. - 2020 оны IV улиралд үйлдвэр ашиглалтад оруулна.
11. Үр дүн:	- Улсын болон орон нутгийн төсөвт бүх төрлийн татвар хураамж хэлбэрээр жил бүр ойролцоогоор 150 сая ам.доллар

	<p>төвлөрүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"><li>- Дотоодын нийт бүтээгдэхүүн 10 орчим хувиар өснө.</li><li>- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 30 орчим хувиар нэмэгдэнэ.</li><li>- Боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 1.5 дахин нэмэгдэнэ.</li><li>- Валютын гарах урсгал 25 орчим хувиар буурч ам.долларын ханш 20-25 хувиар буурна.</li><li>- 600 гаруй шууд, 1000 гаруй шууд бус ажлын байрыг шинээр бий болно.</li><li>- Импортын хэмжээ буурч гадаад худалдааны тэнцлийн ашиг нэмэгдэнэ.</li><li>- Үйлдвэрийг дагаж 30 төрлийн дагалдах үйлдвэрүүд байгуулагдана. /Тос тослогооны материал, будаг, хуванцар, дугуй, резин эдлэл, эм, үнэртэн, гоо сайхны бүтээгдэхүүн, хими цэвэрлэгээ г.м/.</li><li>- Бүтээн байгуулалтын хугацаанд нийт 1 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэж, валютын орох урсгал нэмэгдсэнээр макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, мөнгөний бодлогын орон зайг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.</li></ul>
--	--